

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМ

2015 оны 01 сарын 12

№01

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ч.САЙХАНБИЛЭГ ТАНАА

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Монголын иргэний нийгмийн байгууллагууд 2010 оноос эхлэн Форум хэлбэрээр эвлэлдэн нэгдэж, UPR буюу НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн механизмд идэвхтэй оролцож ирсэн.¹ Монгол Улсын Засгийн Газар олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлд “Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний хоёрдугаар илтгэл”-ийг цаг хугацаанд нь илгээхээр Ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаад Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум сайшааж байна.

Гэвч бид Монгол Улсын Засгийн Газраас хариуцан бэлтгэсэн “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний хоёрдугаар илтгэл”-ийг дараах үндэслэлээр “ҮНДЭСНИЙ ИЛТГЭЛ” хэмээн хүлээн зөвшөөрөх боломжгүй гэдгээ мэдэгдэж байна.

1. UPR буюу НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь НҮБ-ын гишүүн 193 улсын хүний эрхийн төлөв байдлыг 4,5 жил тутам дүгнэн хэлэлцдэг тусгай механизм юм. Тус хэлэлцүүлэг нь ЗГ-ын хариуцан бэлтгэсэн Үндэсний илтгэл, иргэний нийгмийн байгууллагын илгээсэн мэдээлэл, НҮБ-ын хүний эрхийн механизмууд, агентлагуудын дүгнэлт зөвлөмж, мэдээлэлд тулгуурлан явагддаг онцлогтой. Үндэсний илтгэл бол ЗГ-ын байр суурь биш бөгөөд өргөн олон нийтийг оролцуулсан хэлэлцүүлэг, зөвлөлдөх үйл явцад тулгуурлан бэлтгэх учиртай. Харамсалтай нь, жинхэнэ утгаар зөвлөлдөх үйл явц Монголд өрнөсөнгүй. Гадаад Хэргийн Яам, Хууль Зүйн Яам нь 2014 оны 12 сарын 19, 22-ны өдрүүдэд “Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаархи үндэсний хоёрдугаар илтгэл” сэдвийн хүрээнд “Эдийн засаг нийгэм соёлын эрх”, “Иргэний, улс төрийн эрх” хэмээн ангилж хэлэлцүүлэг хийсэн нь дэвшилттэй байсан. Гэсэн хэдий ч илтгэлийн төслийг урьдчилан явуулаагүй, эсхүл илт тулгаж ирүүлсний улмаас ТББ-ууд илтгэлтэй танилцах, мэдээллийг нягтлах, шинэчлэн баяжуулах мөн үгүйсгэх боломж хязгаарлагдмал байв. Мөн тухайн салбарыг хариуцсан албан тушаалтан хэлэлцүүлэгт байгаагүй, эсхүл бүтцийн өөрчлөлтөөр халагдсан ажилтан оролцсон, “Үндэсний илтгэлийн сүүлийн хувилбар биш” гэх мэт шалтгаанаар үр дүнтэй хэлэлцүүлэг болсонгүй. Энэ бүхнээс дүгнэхэд, дээрх хэлэлцүүлгүүд иргэний нийгэмтэй зөвшилцсөн гэх нэр зүүх төдий болсноос бус жинхэнэ утгаар зөвлөлдөх үйл явц өрнөсөнгүй.
2. Үндэсний илтгэл нь агуулгын хувьд шаардлага хангаагүй хэмээн бид үзэж байна. Хэлэлцүүлгийн үеэр бидэнд тараасан илтгэлийн төсөлд НҮБ-ын ХЭЗ-өөс 2010 онд өгсөн 126 Зөвлөмжийн хэрэгжилтээс орхигдуулсан, өнөөдөр үүсч бий болсон нөхцөл байдлыг дутуу тусгасан, бодит байдалд нийцэхгүй дүгнэлт хийсэн зэрэг нийтлэг дутагдал байна.

¹ Монголын Хүний эрхийн ТББ-уудын НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд 2010, 2014 онд илгээсэн мэдээллийг www.upr-mongolia.mn, www.ohchr.org цахим хуудсаар орж үзэх боломжтой.

Гадаад хэргийн яамнаас 2015 оны 1-р сарын 14-ний өдрийн Үндэсний илтгэлийн хэлэлцүүлэгт өнөөдөр урьсан боловч Үндэсний илтгэлийн төслийг бидэнд ирүүлсэнгүй. Үндэсний илтгэлийг 1-р сарын 19-ний өдөр англи хэл дээр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлэх тул, тус зөвлөлдөх уулзалтад оролцож, саналаа тусгах бодит боломжгүй гэж үзэж байна. Иймд Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум нь 1-р сарын 14-ний өдөр зохион байгуулах тус хэлэлцүүлэгт оролцох боломжгүй болохоо үүгээр мэдэгдэж байна.

Цаашид Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хангах, хамгаалах, энэ чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг амлалтаа бүрэн дүүрэн биелүүлэх чадавхиа сайжруулахын тулд Засгийн газар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлаа бодитоор үнэлэх, шаардлагатай чиглэлээр НҮБ-аас техникийн туслалцаа авах дараахи алхмуудыг авч хэрэгжүүлэхийг Танд зөвлөж байна. Үүнд:

1. Төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан хандлагаар үйл ажиллагаагаа явуулах чадавхийг бүрдүүлэх чиглэлээр сургалтад тогтмол хамруулах,
2. НҮБ-ын ХЭЗ-ийн хүний эрхийн төлөв байдал, бусад конвенциудын хэрэгжилтийн тайлан илтгэлийг явуулах зорилго бүхий бүтцийг боловсронгуй болгож, тогтмол ажиллуулах, энэ үйл явцад иргэний нийгмийн бодит оролцоог хангах,
3. НҮБ-ын ХЭЗ-ийн хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн явц, үр дүн болон хүний эрхийн бусад мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэж ажиллах, тэр дундаа хөдөөгийн иргэдэд хүргэхэд онцгойлон анхаарах

Бид Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хүн бүрт тэгш боломж олгохын төлөө төрийн бодлого, үйл ажиллагаанд байнгын хяналт, мониторинг, үнэлгээ хийхийн зэрэгцээ, сайжруулах чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахад бэлэн байна.


Хүндэтгэсэн,

Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форумын гишүүн байгууллага:

1. Оюутолгойн Хяналт ТББ



2. Хүний эрхийн Төлөв Эрхийн төлөв ТББ



Хувийг Хууль зүйн сайд, Гадаад хэргийн сайдад хүргүүлэв.

3. Монголын Эмэгтэйчүүдийн
Хөдөлмөрийн Дэмжих
Холбоо



4. "Сэтгэзүйн мэдэрэм" ТББ *Г. Шинэсүрэн*



5. *Б. Батмөнх* (Signature) *Баруун могойстан Экологийн төв.*



6. "Үндсэн уртраг" ТББ *У. Ганзориг*



7. Хүн хэзвэртэй ахлах ТББ - *У. Дунмагд* / *У. Дунмагд*



8. "Хүний Эрх Кошиг Төв" ТББ *Т. Урансүх* / *Т. Урансүх*



9. Хэрэгсэл сан ТББ - *Г. Оюунсүрэн* / *Г. Оюунсүрэн*



10. Малчдын Эрх зүйлүүдийг хөдөө ТББ. *Д. Сүхбаатар* / *Д. Сүхбаатар*



11. "Товч интернесса төв" ТББ *М. А.*



12. Сан сазлааргүй гол мөрөн




13. Хүн ажиллагааг зориулсан төв



14. *М. А.* (Signature) *У. Батбаяр* / *У. Батбаяр*



15. Монголын Хот Фамил Эргэлт Хөгжил
Урсгалын Байгууллага-уудын
Мэдээллийн Холбоо ТББ *У. Оюундаатар*



16. Монголын Зинэстч Интэрнэт *Б. Алтанмуяа - р*

17. "ЛГБТ Төв" ТББ



Алмуз *Н. Амарраа*

18. Хотын Хөгжлийн Хэлхээ ТББ



19. Монголын Фамил Эргэлт Урсгалын
Урсгалын Холбоо. *Гондшилорч*
М. Цырендал
(М. Цыф)



20. Булагшангу гол мөрний
Эхийн Хамгаалах Сан



Алмуз *ТЭРГҮҮН*
А. Оюунчимэг

21. Ногоон Соёл Иргэншил
Хөгжлийн Сан



Г. Төмөрмөнх *ТЭРГҮҮН*
Г. Төмөрмөнх